



“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит,
2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
дугаар тогтоолын хасралт

“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Женко тур бюро” ХК-ийн /цаашид Компани гэх/ энэхүү дүрэм нь Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах компанийн эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2 Компанийн оноосон нэр:
Монгол хэлээр: “ЖЕНКО ТУР БЮРО” Хувьцаат компани /ХК/
Англи хэлээр: “GENCO TOUR BUREAU” Joint Stock Company /JSC/

Компанийн регистерийн дугаар: 2108011
Улсын бүртгэлийн дугаар: 9011053030

Компанийн оршин байгаа хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-3,
“Баянгол” зочид буудал, оффисийн байр

1.3 Компанийн эрх зүйн байдал: Компани нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах ба тусгайлсан эд хөрөнгөтэй үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгөөрөө хариуцаж өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж үүрэг хүлээдэг бие даасан хуулийн этгээд мөн.

1.4 Компанийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл:
1) Аялал жуулчлал
2) Гадаад худалдаа
3) Дотоод худалдаа-/хүнсний болон ахуйн хэрэглээний бараа/
4) Бэлэг дурсгалын худалдаа



1.5 Компанийн үйл ажиллагаа явуулах хугацаа: Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс хойш үйл ажиллагаагаа хугацааны хязгаарлалтгүйгээр явуулна.
1.6 Компани нь өөрийн бэлэгдэл тэмдэгтэй байх бөгөөд загварыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх ба тэмдгийг хэрэглэх эрхийг “Женко тур бюро” ХК эдэлнэ.
1.7 Компани нь өөрийн албан бичгийн хуудас, тамга тэмдэгтэй байна.

ХОЁР. КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

2.1 Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай ба компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь зарласан хувьцаанаас нийтэд санал гаргасан хувьцааны тоог нэг бүрийн нэрлэсэн үнээр үржүүлсэн үнийн дүнтэй тэнцүү байна.

- 2.2 Компани нь энгийн болон давуу эрхийн хувьцаа нэмж гаргах, хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох, гаргасан хувьцааг бэлэн мөнгө болон биет хөрөнгөөр эргүүлэн авч болно.
- 2.3 Компани нь энгийн хувьцааг худалдан авах эрхийн бичиг, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион (цаашид "Хувьцаанд хөрвөх үнэт цаас" гэх) гаргаж болно.
- 2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд ТУЗ нь Хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж Компанийн тухай хуулийн 39.5-д заасан эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.
- 2.5 Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 2.6 Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй. Харин хувьцаа эзэмшигчид хоорондын гэрээгээр хувьцааг захиран зарцуулах эрхийг тодорхой хэмжээгээр харилцан хязгаарлаж болно. Компани нь хуульд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдээс хувьцааг нь эргүүлэн авах эрхтэй.
- 2.7 Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу өрийн бичиг гаргаж болно.
- 2.8 Компанийн гаргасан үнэт цаасны төлбөрийг мөнгө болон бусад хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр хийх тохиолдолд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үнэлгээг тогтооно.
- 2.9 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болох ба ногдол ашиг олгох хугацааг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

ГУРАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

А. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 3.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хуралтай байна.
- 3.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн эхний 4 сарын дотор Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс зарлан хуралдуулна.
- ✓ 3.4 Туз нь ХЭХ-н зарыг санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 сарын 15-ны өдөр Дугаар 34 тогтоолоор баталсан ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ ЖУРАМ -н дагуу хувьцаа эзэмшигч нарт хүргүүлнэ.
- 1 Хувь нийлүүлэгчдийн ээлжит, 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 06/2014 дүгээр тогтоолоор батлав/*
- 3.5 Дараах тохиолдолд Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 3.5.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон,
- 3.5.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3-аас доошгүй гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан,
- 3.5.3 Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн,


- 3.5.4 Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон,
- 3.5.5 Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан,
- 3.5.6 Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан,
- 3.6 Компанийн дүрмийн 3.4.2-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргах бөгөөд шаардлага гаргасан этгээдийн эцэг /эх/-ийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, өөрийн эзэмшиж байгаа хувьцааны тоог заана.
- 3.7 Төлөөн удирдах зөвлөл нь шаардлага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хурал хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана. Энэ заасан хугацаанд ТУЗ шийдвэр гаргаагүй тохиолдолд шаардлага тавьсан этгээд хурлыг энэхүү дүрмийн дагуу хуралдуулах шийдвэр гаргана.
- 3.8 Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн хадгаламжийн төв компаниас гаргана.
- 3.9 Хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.
- 3.9.1 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлан, түүний дараах аудиторын болон ТУЗ-ийн дүгнэлт
- 3.9.2 Өмнөх санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий болон их хэмжээний хэлцлүүд
- 3.9.3 Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга
- 3.9.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай зайлшгүй холбоотой бусад мэдээлэл, шийдвэрийн төсөл
- 3.10 Хувьцаа эзэмшигчид нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлж болно.
- 3.11 Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцно.
- 3.12 Саналын эрх бүхий хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалтад оруулах шаардлагатай гэж үзсэн өөр асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд хуульд заасан хугацаанд бичгээр ирүүлж болно.
- 3.13 Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хурлын товыг "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.
- 3.14 Дараахь асуудлуудыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 3.14.1 Компанийн дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
- 3.14.2 Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах
- 3.14.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах түүний тоог тогтоох
- 3.14.4 Хувьцааг хуваах нэгтгэх
- 3.14.5 Компанийг татан буулгах комиссыг томилох
- 3.14.6 Төлөөлөн Удирдах Зөвлөл гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, тэдгээрийн жилийн тайланг батлах

- 3.14.7 Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
- 3.14.8 Компанийн дүрэм болон энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан бусад асуудлууд
- 3.15 Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 3.16 Компанийн тухай хуулинд зааснаар дийлэнх олонхоор, эсвэл кумулятив аргаар шийдэх асуудлаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 3.17 Хурлын тооллогын комисс, санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох нөхцөл, эчнээ санал хураалт хийх журам, хурлын тэмдэглэл хийх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд компанийн тухай хуулийг баримтална.

Б. Төлөөлөн Удирдах Зөвлөл

- 3.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ байна.
- 3.19 Төлөөлөн Удирдах Зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 1 жилийн хугацаатай сонгож ажиллуулна. Үүний 3-аас доошгүй гишүүн нь хараат бус байна. ТУЗ-ийн гишүүн нь компанийн хувьцаа эзэмшигч биш хувь хүн байж болно.
- 3.20 ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудлыг санаачлан хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
 - 3.20.1 Компанийн үйл ажиллагааны стратеги болон бизнес төлөвлөгөөг батлах
 - 3.20.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болон түүнтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх
 - 3.20.3 Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах
 - 3.20.4 Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох
 - 3.20.5 Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, гэрээ байгуулах, түний бүрэн эрхийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих
 - 3.20.6 Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг сонгох
 - 3.20.7 Опцион, өрийн бичиг болон компанийн дүрэмд заасан бусад үнэт цаас гаргах, түүний төрөл, тоо, гаргах хугацаа, хувьцаанд хөрвөх нөхцлийг тодорхойлох
 - 3.20.8 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, өөрийн хөрөнгөд оруулах өөрчлөлтийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулах
 - 3.20.9 ТУЗ, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах
 - 3.20.10 Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж шийдвэр гаргах
 - 3.20.11 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах
 - 3.20.12 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх
 - 3.20.13 Компанийн удирдлагыг урамшуулах зорилгоор компанийн хувьцааны энэ дүрэмд заасан хэсгийг менежментэд эзэмшүүлэх талаар шийдвэр гаргах
 - 3.20.14 ТУЗ-ийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, тэдгээрийн цалин урамшууллын хэмжээг цалин урамшууллын хорооны саналаар батлагдсан төсөвт багтааж тогтоох

- 3.20.15 Гүйцэтгэх захирлын санал болгосноор түүний ажлын аппарат, компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоог батлах, цалингийн санг тогтоох, шагнал урамшуулын дүрэм баталж мөрдүүлэх
- 3.20.16 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах
- 3.21 ТУЗ нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлнэ.
- 3.22 ТУЗ-ийн гишүүн бүрмөсөн буюу удаан хугацаагаар ТУЗ-ийн гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд төлөөлөх гишүүнийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилж болно.
- 3.23 ТУЗ-ийн ажил үүргээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. ТУЗ-ийн 6-аас доошгүй гишүүн хуралд оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба зайлшгүй шаардлагын улмаас ТУЗ-ийн гишүүн хуралд биеэр оролцож чадаагүй тохиолдолд урьдчилан хурлын хэлэлцэх асуудалтай танилцсаны үндсэн дээр саналаа бичгээр ирүүлж хуралд оролцож болно. ТУЗ эцнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 3.24 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон шаардлагаар хуралдуулна.
- 3.25 ТУЗ-өөр хэлэлцсэн асуудлыг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэсэн асуудлаар ТУЗ-ийн хурлын тогтоол гаргаж зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагч талын саналаар шийдвэрлэсэнд тооцно.
- 3.26 ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн даргыг сонгоно. ТУЗ-ийн дарга нь компанийн Гүйцэтгэх захирал байж болохгүй.
- 3.27 ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсвэл ТУЗ-ийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 3.28 ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, гаргасан шийдвэрт хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.
- 3.29 ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх удирлагыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-ийн хуралд оруулах, ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, ТУЗ-ийн төсвийг хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 3.30 ТУЗ нь хурлаасаа сонгосон орон тооны бус нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүн бус харин удирдах багийн гишүүн байж болно.
- 3.31 Нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хурлын зар, товыг мэдээлж, хурлаас гарах шийдвэрийн төслийг бэлдэж тараах, тэмдэглэл хөтлөх, бичиг хэрэг нууц хадгалалтыг хариуцна. Түүнчлэн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавина.
- 3.32 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.



/ Хувь нийлүүлэгчдийн ээлжит, 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 06/2014 дүгээр тогтоолоор батлав/

3.33 ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороотой байна. Эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс

✓ бүрдэх ба Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасан болон компанийн ТУЗ-н үйл ажиллагааны журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

I Хувь нийлүүлэгчдийн ээлжит, 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 06/2014 дүгээр тогтоолоор батлав/

В. Гүйцэтгэх захирал

- 3.34 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 3.35 ТУЗ-ийн дарга буюу 3-аас доошгүй гишүүн нэгдэн санал болгосноор нэр дэвшүүлж, ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олонх нь дэмжсэнээр ТУЗ нь Гүйцэтгэх захиралтай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулж, түүний эрх үүрэг, хариуцлага, цалин урамшууллын хорооноос санал болгосон цалин урамшуулалыг тогтоох зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.36 Гүйцэтгэх захирал дараах эрх үүрэгтэй байна.
 - 3.36.1 ТУЗ нь гүйцэтгэх захиралыг сонгон томилох бөгөөд гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомж болон гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд заасны дагуу эрх залгамжлагч нь шинээр томилогдох эсвэл хугацаанаасаа өмнө огцрох буюу чөлөөлөгдөх хүртэлх хугацаанд албан үүргээ гүйцэтгэнэ. Гүйцэтгэх захирал нь компанийн гүйцэтгэх удирдлагын дээд албан тушаалтан байх ба Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага болон хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бүх тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангана.
 - 3.36.2 Олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэхгүйгээр үйл ажиллагаа явуулах
 - 3.36.3 Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах
 - 3.36.4 Компани, хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах
 - 3.36.5 Компанийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулж ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлын дотоод журмыг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хамтын гэрээ, хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.
 - 3.36.6 Санхүүгийн үйл ажиллагааг биечлэн удирдаж, санхүүгийн тайлан бүртгэлд хяналт тавина.
 - 3.36.7 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Хяналтын байгууллагад гаргасан компанийн үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
 - 3.36.8 ТУЗ-ийн зөвшөөрлөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
 - 3.36.9 ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай санал гаргана.
 - 3.36.10 Гүйцэтгэх захирлын ажлын аппарат, менежментийн багийг бүрдүүлж ажиллана.

3.36.11 Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн хооронд байгуулсан гэрээнд заасан бусад эрх, үүрэг

Г. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага

3.37 Эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий ня-бо, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ, хэлцэл хийхэд оролцдог албан тушаалтан орно.

3.38 Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно: хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг, шийтгэл эдэлж байгаа.

Хувь нийлүүлэгчдийн ээлжит, 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 06/2014 дүгээр тогтоолоор батлав/

3.39 Эрх бүхий албан тушаалтан компанийн дотоод журам, ажил үүргийн хуваарийн дагуу ажиллах ба компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллахын зэрэгцээ компанийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргах, компанийн ажил үүргийг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахгүй байх,

3.40 Эрх бүхий албан тушаалтан компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно. Түүнчлэн ажлаас гарснаас хойш 3 жилийн дотор нууцыг задруулахгүй байх

3.41 Эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас /үүнд бизнесийн эрсдэл үл хамаарна/ компанид учруулсан хохирлыг тухайлбал, мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй, хуурамч мэдээлэл өгсөн, компанийн нэрийг хувийн зорилгод ашигласан, баримт бичгийг зөв хадгалаагүй г.м. өөрөө бүрэн хариуцна.

3.42 Компанийн эрх бүхий албан тушаалтан түүний эрх үүргийн хэм хэмжээ, түүнд тооцох хариуцлагыг хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ. Сахилгын арга хэмжээ авагдсан явдал хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ, ТАЙЛАН, АШИГ ХУВААРИЛАЛТ

А. Нягтлан бодох бүртгэл, тайлан, ашиг хуваарилалт

4.1 Компани нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах бөгөөд эрх бүхий этгээдэд зохих хугацаанд хүргүүлэн нийтэд мэдээлнэ.

4.2 Компанийн санхүүгийн тайланд дараахь зүйлийг тусгана

4.2.1 Баланс

4.2.2 Орлого, үр дүнгийн тайлан

4.2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

4.2.4 Хуримтлагдсан ашгийн тайлан

4.2.5 Нэмэлт тайлан

4.2.6 Бусад

4.3 Компани нь жил бүрийн үйл ажиллагааны цэвэр ашгийг төсөвлөж зарцуулна. Үүнд: Урт богино хугацааны хөрөнгө оруулалт, компанийн ажиллагсдын нийгмийн асуудал, шагнал, урамшил, компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох шагнал урамшуулал, компанийн хувьцаа эзэмшигч нарт олгох ногдол ашиг зэрэг болно.

4.4 Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол компанийн жилийн цэвэр ашгийн 20-оос доошгүй хувиар ногдол ашиг хуваарилж байна.

4.5 Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэж 12 дугаар сарын 31-ны өдрөөр хаагдана.

4.6. Өөрийн хувьцаа эзэмшигч нарт компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигч нарын нэр, хувьцааны нэр төрөл, тоо, Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон мэдээллийг танилцуулна.

Б. Аудит

4.5 Компани нь санхүүгийн тайланг шалгуулах, баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагааны бүрэн эсвэл хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг ажиллуулна.

4.6 Аудиторын ээлжит шалгалтаар компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулна. Ээлжит бус аудитын шалгалтыг ТУЗ, түүний аудитын хороо, 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийлгэж болно.

4.7 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудитын шаардлагаар компанийн санхүү эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

Тав. Компанийг татан буулгах

5.1 Компанийг хувьцаа эзэмшигчдийн болон шүүхийн шийдвэрээр хуульд заасан үндэслэлээр татан буулгана. Компанийг татан буулгах үед хуульд заасан өр төлбөрийг нь барагдуулах, хувьцаа эзэмшигчдэд эд хөрөнгийг нь хуваарилах ба бусад асуудлыг шийдвэрлэнэ.

Зургаа. Бусад зүйлс

6.1 Энэхүү дүрэмд заагаагүй эрх зүйн харьцаануудыг холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилнэ.

"ЖЕНКО ТУР БЮРО" ХУВЬЦААТ КОМПАНИ